



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2024/09/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Баруун-Урт 2024 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Н.Болдбаатар Утас: 70512127 Цахим хаяг: boldbaatarn@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-  
ЫН ЗАХИРАЛ Ж.СҮРЭНХҮҮ ТАНАА

2024.03.15 № 225  
танай \_\_\_\_\_ - ны№ \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2023 оны А/19, 06, 07 тоот захирамжаар 453,878.7 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг урьдчилж орсон орлогоор, газар эзэмших эрх 90,000.0 мянган төгрөгийг биет бус хөрөнгөнд бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Орон нутгийн өмчит аж ахуйн аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиг үүрэгт амралт, тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг нэмж, дүрмийг шинэчлэн баталсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аймгийн Засаг даргын 2023 оны А/190, А/287 дугаар тогтоолоор “Сүхбаатар Нийтлэг үйлчилгээ” ОНӨААТҮГ-ийн 2023 оны эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшин, зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталсан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>101,934,419.99</b>	<b>141,263,793.25</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>169,833.51</b>	<b>42,722,081.25</b>
<b>31100</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>54,538.00</b>	<b>14,485.00</b>
31110	Төгрөг	54,538.00	14,485.00
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>115,295.51</b>	<b>42,707,596.25</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>115,295.51</b>	<b>42,707,596.25</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	115,295.51	42,707,596.25
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>44,407,322.00</b>	<b>40,957,322.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>44,407,322.00</b>	<b>40,957,322.00</b>
33520	Хувь хүмүүсээс авах авлага	44,407,322.00	40,957,322.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>57,357,264.48</b>	<b>57,584,390.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>57,357,264.48</b>	<b>57,584,390.00</b>
35420	Аж ахуйн материал	57,357,264.48	57,584,390.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>51,640,348.12</b>	<b>470,228,848.07</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>51,640,348.12</b>	<b>470,228,848.07</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>51,640,348.12</b>	<b>380,228,848.07</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	17,500,000.00	210,846,533.39
39204	Хуримтлагдсан элэгдэл	-12,237,500.00	-55,796,820.01
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	24,030,189.00	43,366,079.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,011,396.44	-27,492,249.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	213,521,761.00	260,068,551.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-180,162,705.44	-218,282,334.41
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>153,574,768.11</b>	<b>611,492,641.32</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>71,322,292.17</b>	<b>432,206,780.97</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>71,322,292.17</b>	<b>432,206,780.97</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>55,953,652.17</b>	<b>52,443,956.14</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>55,953,652.17</b>	<b>52,443,956.14</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	33,581,850.00	49,814,798.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	19,692,749.43	2,629,158.14
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	2,679,052.74	0
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>15,368,640.00</b>	<b>379,762,824.83</b>
41440	Бусад урьдчилж орсон орлого	15,368,640.00	379,762,824.83
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>82,252,475.94</b>	<b>179,285,860.35</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>82,252,475.94</b>	<b>179,285,860.35</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	329,690,240.18	419,690,240.18
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	329,690,240.18	419,690,240.18
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-247,437,764.24</b>	<b>-240,404,379.83</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-274,611,066.24	-247,437,764.24
51220	Тайлант үеийн үр дүн	27,173,302.00	7,033,384.41
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>153,574,768.11</b>	<b>611,492,641.32</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>657,258,399.80</b>	<b>831,864,070.38</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>657,258,399.80</b>	<b>831,864,070.38</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>657,258,399.80</b>	<b>831,864,070.38</b>
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	657,258,399.80	806,643,332.38
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		25,220,738.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>628,464,724.48</b>	<b>824,830,685.97</b>
210	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	400,589,783.40	554,097,507.40
210812	Санхүүгийн зардал	161,055.31	169,000.00
210813	Бусад зардал	224,694,630.00	270,564,178.57
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>28,793,675.32</b>	<b>7,033,384.41</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		
	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	1,620,373.32	
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>27,173,302.00</b>	<b>7,033,384.41</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>1</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>-274,611,066.24</b>	<b>55,079,173.94</b>
<b>2</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>-274,611,066.24</b>	<b>55,079,173.94</b>
<b>3</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>		<b>27,173,302.00</b>
<b>4</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>-274,611,066.24</b>	<b>82,252,475.94</b>
<b>5</b>	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>-274,611,066.24</b>	<b>82,252,475.94</b>
<b>6</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>-274,611,066.24</b>	<b>82,252,475.94</b>
<b>7</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>27,173,302.00</b>	<b>7,033,384.41</b>
<b>8</b>	<b>Өмчит гарсан өөрчлөлт</b>	<b>329,690,240.18</b>	<b>90,000,000.00</b>
<b>9</b>	<b>2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>82,252,475.94</b>	<b>179,285,860.35</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>657,654,376.00</b>	<b>830,303,727.74</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>657,654,376.00</b>	<b>830,303,727.74</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>657,654,376.00</b>	<b>830,303,727.74</b>
120009	Бусад орлого	263,330,184.00	164,349,985.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	97,245,036.00	165,182,470.00
120017	Татаас, санхүүжилтийн орлого /ТӨҮГ/	297,079,156.00	500,771,272.74
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>648,869,562.07</b>	<b>764,981,480.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>648,869,562.07</b>	<b>764,981,480.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>648,869,562.07</b>	<b>764,981,480.00</b>

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>237,552,513.00</b>	<b>354,771,641.00</b>
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	237,552,513.00	354,771,641.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>61,849,518.40</b>	<b>103,643,597.18</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	61,849,518.40	103,643,597.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,223,461.23</b>	<b>7,288,839.37</b>
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	4,223,461.23	7,288,839.37
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>197,227,215.00</b>	<b>185,877,768.21</b>
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	25,811,310.00	9,336,075.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	171,415,905.00	176,541,693.21
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>148,016,854.44</b>	<b>113,399,634.24</b>
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	28,521,134.44	48,839,247.24
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	119,495,720.00	64,560,387.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>8,784,813.93</b>	<b>65,322,247.74</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>11,810,000.00</b>	<b>22,770,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,810,000.00</b>	<b>22,770,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>11,810,000.00</b>	<b>22,770,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,810,000.00	22,770,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-11,810,000.00</b>	<b>-22,770,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-3,025,186.07</b>	<b>42,522,247.74</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,195,019.58	169,833.51
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	169,833.51	42,722,081.25

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 59,597.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 59,597.6 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд 40.0 сая төгрөгийг зардлыг дутуу илэрхийлсэн.
- Мөнгөн гүйлгээний тайланд үйлчилгээ үзүүлсний орлого 1.3 сая төгрөгийг дутуу тусгасан.
- Мөнгөн гүйлгээний тайланд мөнгөн зарлагыг 18.1 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 52,444.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 52,444.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

### 3.1 Зөвлөмж

#### 3.1.1 Өр төлбөртэй холбоотой

##### Илрүүлэлт.

Байгууллагын үйл ажиллагааг зохистой удирдан өр авлага үүсгэхгүй байх зарчмын хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулалгүй 52,444.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 /хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/ дахь заалтыг зөрчсөн ба оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Өр төлбөр үүсэх тохиолдолд тухайн жилд нь байгууллагын захирал удирдан, өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авч шийдвэрлэж байх.

#### 3.1.2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт: Аймгийн ИТХ-ын 06 тогтоолын дагуу 2 автомашиныг шилжүүлэн авч данс бүртгэлд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/ дахь заалтыг зөрчсөн ба оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж

Хөрөнгийн асуудлыг зохих шатны байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээг зохион байгуулж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлогын дэлгэрэнгүй тайланд зардлыг дутуу илэрхийлсэн.	1	40,032.6	1	40,032.6			1	40,032.6	-	-	-	-
Мөнгөн гүйлгээний	1	1,350.0	1	1,350.0			1	1,350.0				

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тайланд орлого дутуу тусгасан.												
Мөнгөн гүйлгээний тайланд зарлагыг дутуу илэрхийлсэн.	1	18,215.0	1	18,215.0			1	18,215.0				
Дүн	3	59,597.6	3	59,597.6	-	-	3	59,597.6	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын үйл ажиллагааг зохистой удирдан өр авлага үүсгэхгүй байх зарчмын хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулалгүй өр төлбөр үүсгэсэн.	1	52,444.0	-	-	-	-	1	52,444.0	-	-	-	-
Хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй	1	-					1	-				
Дүн	2	52,444.0	-	-	-	-	2	52,444.0	-	-	-	-